

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарын 2023 оны  
98 дугаар түшүүлэлийн 6 дугаар хавсралт

Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт бэлтгэл, сургалтын офицер хошууч Д.Нямчулууны  
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| д/д | Зорилтыг<br>хэрэгжүүлэх арга<br>хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин |              |                         |                                |                    |
|-----|--|------------------|---------------------|--------------|-------------------------|--------------------------------|--------------------|
|     |  |                  | Суурь түвшин        | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн,<br>дууссан<br>хугацаа | Биелэлтийн<br>хувь |
| 1   | 2                                      | 3                | 4                   | 5            | 6                       | 7                              |                    |

Зорилт 1. "Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулах"

|     |  |   |                                       |                                      |   |                           |      |
|-----|--|---|---------------------------------------|--------------------------------------|---|---------------------------|------|
| 1.1 | Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчиний үйл ажиллагааг аймгийн иргэд, хөдөлмөрчид, цэргийн насын залуучуудад сурталчилах | Too: 5<br>Чанар: Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны хуваарийн дагуу зохион байгуулж иргэдийн 25 хүртлэх хувийг хамруuлах | Иргэдийн 15 жүртэлх хувийг хамruулсан | Иргэдийн 20 жүртэлх хувийг хамruулна | <p>Төрийн батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг олон түмэнд хүргэх, нийгэмд Зэвсэгт хүчиний нэр хүндийг өсгөх, өсвөр үе хүүхэд залуучуудын бие бялдар, ур чадварыг хөгжүүлэх, цэрэг эх оронч хүмүүжил олгох, бие бялдын өв тэгш хөгжилтэй залуу хойч үеийг төлөвшүүлэх, иргэн цэргийн харилцааг хөгжүүлэх, цэргийн насын залуусын боловсрол, эрүүл мэндийг дээшлүүлэх, салбарын хууль тогтоомжийг сурталчлах, иргэдийг цэргийн гэрээт албанад элсүүлэх зэрэг ажилд онцгой анхаарал хандуулан ажилласан.</p> <p>2024 оны жилийн эцсийн байдлаар батлан хамгаалах салбарын мэдээ мэдээллийг ил тод нээлттэй хүргэх ажлын хүрээнд аймгийн ЗДТГ, Цэргийн штабын цахим хуудсанд нийт 27 мэдээлэл байршиулж, 18-54 насын 25391 иргэнээс 5130 иргэн буюу 20.2 хувьд мэдээ мэдээллийг хүргээд байна.</p> | 2024.02.01-<br>2024.12.29 | 100% |
|-----|--|---|---------------------------------------|--------------------------------------|---|---------------------------|------|

|     |   |  |   |  |  |
|-----|---|--|---|--|--|
|     |   |  |   |  |  |
| 1.2 | Багийн Засаг дарга нарын сургалтыг зохион явуулах | Тоо: 1<br>Чанар: Багийн Засаг дарга нарын мэдлэг, чадвар дээшилж чадавх нэмэгдсэн байх | Багийн Засаг дарга нарын “Цэргийн бэлтгэл” сургалтыг 1 удаа зохион байгуулсан | Багийн Засаг дарга нарын “Цэргийн бэлтгэл” сургалтыг 1 удаа зохион байгуулна | <p>Дайчилгааны тухай хуулийн тавдугаар бүлгийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Орхон аймагт төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх гэрээний 1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2024 оны А/592 дугаар захирамж, Цэргийн штабын 2024 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 2024 оны 08 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд багийн Засаг дарга нарын сургалтыг Цэргийн штабын сургалтын танхим болон Зэвсэгт хүчиний 186 дугаар анти, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг түшиглэн зохион байгуулсан. Цэргийн бэлтгэл сургалтыг 4 жилийн хугацаанд 4 шатлалтайгаар буюу жил бүр 3 хоногийн хугацаатай нийт 96 цаг, жилд 24 цагийн багтаамжтайгаар өдрийн 8 цагаар, 1 цаг нь 45 минут байхаар төлөвлөж, батлагдсан хөтөлбөрийн дагуу “Аюулгүй байдлын үндэс” 3 цаг, “Батлан хамгаалах бодлого, эрх зүй” 3 цаг, “Цэргийн албаны тухай ойлголт” 3 цаг, “Дайчилгааны бэлтгэл” 2 цаг, “Орон нутгийн хамгаалалт” 9 цаг, “Цэргийн ерөнхий бэлтгэл” 4 цаг гэсэн 6 хичээлийн хүрээнд 2024 онд нийт 24 цагийн сургалтыг лекц, дадлага, хэлэлцүүлэг, бүлгийн дасгал хэлбэрээр зохион явуулж, сургалтад Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын дарга, баг хариуцсан мэргэжилтэн, багийн Засаг дарга нар 26, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын дарга, багийн Засаг дарга 3, нийт 32 хүний бүрэлдэхүүнтэй</p> <p>2024.10.03-2024.10.05</p> <p>100%</p> |

|     |   |  |   |  |  |                       |      |  |
|-----|---|--|---|--|--|-----------------------|------|--|
|     |   |  |   |  | багийн Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалтын дөрөвдүгээр шатны сургалтыг зохион явууллаа.  |                       |      |  |
| 1.3 | Зэвсэгт хүчний 103 жилийн ой, чөлөөлөх дайны 79 жилийн ойн баярын арга хэмжээг тусгай төлөвлөгөөгөөр зохион байгуулах | Too: 2<br>Чанар: Арга хэмжээг тогтоосон хугацаанд зохион байгуулах | Төлөвлөсөн арга хэмжээг зохион байгуулсан | Төлөвлөсөн арга хэмжээг зохион байгуулсан байх | <p>Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчиний Ерөнхий командлагчийн албан даалгаврын хэрэгжилтийг хангах, Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалахын зарим чиг үүргийг Орхон аймагт төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх гэрзэ, Аймгийн Засаг даргын 2024 оны А/92 тоот захирамжийн дагуу тусгай хөтөлбөр, төлөвлөгөө гарган дараах арга хэмжээг шат дараатай зохион байгууллаа.</p> <p>2024 оны 03 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд Зэвсэгт хүчиний 186 дугаар ангийн сургалтын төвд Аймгийн Засаг даргын нэрэмжит “Марш-тактикийн аварга тасаг” шалгаруулаж тэмцээн, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлагын дундах багийн буудлагын тэмцээн, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нарын дундах буудлагын тэмцээн болон Нутгийн удирдлагын ордонд үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудын албан хаагчдын дундах багийн буудлагын тэмцээн.</p> <p>2024 оны 03 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд Орхон аймаг дахь, “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль, Политехникийн коллежийн сюутан сургачдын дунд “Миний эх орон миний мөрөөдөл” сэдэвт эсээ бичлэгийн уралдаан, Ерөнхий боловсролын ахлах ангийн сургачдын дунд Хийн буудлагын багийн тэмцээн, бага ангийн сургачдын дунд Цэрэг эх орны сэдэвт гар зургийн уралдаан, тэмцээнүүдийг тус тус амжилттай зохион байгууллаа.</p> | 2024.03.01-2024.03.19 | 100% |  |

2024 оны 03 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд 1945 оны чөлөөлөх дайчд оролцож явсан ахмад дайчин Гончигийн Дугаржав болон Цэргийн штабаас бэлгэл, чөлөөнд гарсан ахмадуудад хүндэтгэл үзүүлэн, Эрдэнээт Цэргийн хүрээний ангий, салбаруудын "Нэгдсэн тооллого" хийж, Аймаг, сумдын алдар цэлтой хүчит 64 бөхийн барилдааныг зохиин байгууллаа.

2024 оны 03 дугаар сарын 18-нд "Монгол цэргийн өдөр" Зэвсэгт хүчиний 103 ойн баярыг тохиолдуулан Цэргийн штабаас эзхион байгуулсан уралдаан тэмцээний нэгдсэн шагнал гардуулах арга хэмжээг, "Эрдэнэг үйлдвэр" Төрийн өмчигт үйлдвэрийн газрын "Уурхайчин" соёлын цргцолборгийт хамтран "Монгол Улсын төлөө зүтгээ" үргэлийн Нэгдсэн тогтолцын хамт зохион байгуулан Зэвсэгт хүчиний 110, 186 дугаар ангийн, офицер, ахлагч, Цэргийн гэрээт болон хугацаат албаны турүүч байдагчдыг ар гэрийн төлөөллийн хамт үзүүлж сонирхуулсан. Монгол Цэргийн өдөр, Зэвсэгт хүчиний 103 жилийн ойн баярын тэмдэглэлт өдриүүдэд зохион байгуулсан уралдаан тэмцээн, нэгдсэн арга хэмжээнд нийт 15 байгууллагын 850 гаруй төрийн цэргийн болон хувь сахиулах байгууллагын баатмацид, боловсрол, соёл урлагийн салбарын албан хаагчид оролцсон.

Монгол Цэргийн өдөр, Зэвсэгт хүчиний 103 жил, Халхын голын 1939 оны байгаадааны ялалтын 85 жил, 1945 оны чөлөөлөх дайны түүхт 79 жилийн ойт тохиолдуулан зохион байгуулсан дээрх арга хэмжээнүүд нь аймгийн удирдлага болон иргэдээс талархан хулээсэн Эрдэнэт хотын иргэд, хүүхэд заплууудад, эх оронч үзлийг төлөвшүүлэх,

|     |  |   |   |  |  |                           |      |
|-----|--|---|---|--|--|---------------------------|------|
|     |  |   |   |  | Oрон нутгийн төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын хамтын үйл ажиллагааг жигдруулэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэхэд онцгой ач холбогдолтой, үр дүнтэй арга хэмжээ болж өнгөрлөө.  |                           |      |
| 1.4 | "Хүүхэд<br>зaluучуудад эх<br>оронч үзэл<br>төлөвшүүлэх<br>үндэсний<br>хөтөлбөр"-ийг<br>хэрэгжүүлэх арга<br>хэмжээг үе<br>шаттайгаар зохион<br>байгуулж, цэргийн<br>насны болон ёсвэр<br>насны иргэдийн<br>дунд цэрэг-эх оронч<br>хүмүүжил олгоход<br>чиглэсэн арга<br>хэмжээ зохион<br>байгуулах | Тоо: 3<br>Чанар: Хүүхэд,<br>зaluучуудын цэрэг-<br>эх оронч үзэл олгож<br>мэдлэгийн түвшин<br>дээшилсэн байх | Төлөвлесен З-<br>аас доошгүй<br>ажил зохион<br>байгуулсан | Төлөвлесен З-<br>аас доошгүй<br>ажил зохион<br>байгуулах | <p>"Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд Олон улсын энхийг сахиулагчдын өдөр Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн байранд 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдөр "Цэргийн тангараг" давтах ажиллагааг зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдыг оролцуулан өргөн хүрээнд зохион явуулсан. Орхон аймаг дахь Монгол цэргийн нэгдсэн холбоотой хамтран Ш.Огтонбилэгийн нэрэмжит "Эрдэнэт цогцолбор сургуулийн нэгдүгээр дамжааны 100 гаруй оюутанд "Бидний баахархал" сэдэвт лекц зохион байгуулсан. Мөн "Эрдэнэт цогцолбор" дээд сургууль, Политехникийн коллежийн оюутан сурагчдын дунд "Миний эх орон миний мөрөөдөл" сэдэвт эсэс бичлэгийн уралдаан, ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын дунд "Хийн буудлага"-ын багийн тэмцээн, бага ангийн сурагчдын дунд "Цэрэг эх орон"-ы сэдэвт гар зургийн уралдаан, тэмцээнүүдийг зохион байгуулсан.</p> <p>Жил бүр Монгол Улсын зaluучуудын өдрийг тохиолдуулан үндэсний хэмжээнд зохион байгуулдаг Зaluучуудын хөгжлийн сарын аяны хүрээнд "ЭХ ОРОНЧ ЗАЛУУ" сургалтыг Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын төлөөлөл болон 200 орчим оюутан залуусыг оролцуулсан арга хэмжээг зохион байгуулаад байна.</p> | 2024.03.01-<br>2024.12.29 | 100% |

|     |  |   |                               |   |  |
|-----|--|---|-------------------------------|---|--|
|     |  |   |                               |   |  |
| 1.5 | <p>Аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд цэрэг-спортын "ДӨЛ" цогцолбор тэмцээнийг зохион байгуулж, тэргүүн байранд шалгарсан багийг Улсын аварга шалгаруулах тэмцээнд орфолцуулах бэлтгэлийг хангах</p> | <p>Тоо: 1<br/>Чанар: ЕБС-уудын оролцоо нэмэгдэж чадавх дээшлэсэн байх</p> | <p>Боловсруулалт хийгдсэн</p> | <p>Орхон аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газраас баталсан "Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр", Их эзэн Чингис хаан мэндэлсний 862 жилийн ойн хүрээнд хүүхэд, залуучуудад тусгаар тогтол, үндэсний эрх, эрх чөлөөний үнэ цэнийг ойлгуулах, эх ороороо болон Монгол хүн болж төрснөөрөө бахархах, эх байгаль, түүх соёлоо хайллан хамгаалах ухамсартай, эх оронч иргэнийг төлөвшүүлэх, Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Орхон аймагт төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх гэрээний 1.6 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2024 оны А/603 дугаар захирамжийн дагуу аймгийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын "ДӨЛ" цогцолбор тэмцээнийг 2024 оны 09 дүгээр сарын 21, 22-ны өдрүүдэд аймгийн Эрдэнэт спорт амралтын хүрээлэнд амжилттай зохион байгууллаа.</p> <p>Тус тэмцээнд 12 сургуулийн 156 сурагч хурд, хүч, авхаалж самбаа, мэдлэг чадвараа сорин асуулт, хариулт, эсээ бичлэгийн уралдаан, гарцааны өмнөх ажиллагаа буюу жагсаалын үзүүлэх тоглолт, гардан тулааны үзүүлэх тоглолт, тасгийн захирагчийн тэмцээн, марш гүйлтийн тэмцээн зэрэг 16 төрлөөр зохион байгуулж явууллаа. Тэмцээний нийлбэр дүнгээр:</p> | <p>2024.09.28-2024.09.29</p> <p>100%</p> |

611

|   |   |  |                                   |                                  |   |   |      |
|---|---|--|-----------------------------------|----------------------------------|---|---|------|
|   |   |  |                                   |                                  | "Тэргүүн байрт"-т Ж.Батнайрамдал тасгийн захирагчтай Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын 14 дүгээр сургууль шилжин явах цом, алтан медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, "Дэд байрт"-т Б.Анх-Энх тасгийн захирагчтай ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль мөнгөн медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, "Гутгаар байрт"-т Х.Мөнхсуврага тасгийн захирагчтай ерөнхий боловсролын 7 дугаар сургууль хүрэл медаль, өргөмжлөл мөнгөн шагнал, "Тусгай байр"-т Ж.Намуун-Эрдэнэ тасгийн захирагчтай 18 дугаар сургууль өргөмжлөл мөнгөн шагналаар тус тус шагнагдсан байна.   |   |      |
| Зорилт 2. "Цэргийн бүртгэл, цэрэг халалт, татлага зохион байгуулах, цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдтэй сургалт явуулах, мөнгөн төлбөрийн тооцоо хийх" |   |  |                                   |                                  |   |   |      |
| 2.1   | Хугацаат цэргийн албаны цэрэг халалт, татлагыг зохион байгуулах | Тоо: 2<br>Чанар: Хуулийн дагуу хугацаат цэргийн алба хаалгах | Хяналтын тоог 100 хувь биелүүлсэн | Хяналтын тоог 100 хувь биелүүлнэ | <p>Аймгийн Засаг даргын 2024 оны А/279 дүгээр захирамжийн дагуу 2023 оны I ээлжээр татагдсан цэргүүдийг хүлээн авах, 2024 оны I ээлжийн цэрэг татлагын ажлыг зохион байгуулах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.</p> <p>2024 оны 04 дүгээр сарын 26, 27-ны өдрүүдэд I ээлжийн цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулж, 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Хилийн цэргийн төв дамжинд хүргэж, хүлээлгэн өгсэн.</p> <p>Мөн аймгийн Засаг даргын 2024 оны А/697 дугаар захирамжийн дагуу 2023 оны II ээлжийн цэрэг халалт, 2024 оны II ээлжийн цэрэг татлагын ажлуудыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>2024 оны 10 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд II ээлжийн цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулж, 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Зэвсэгт хүчний Төв дамжинд хүлээлгэн өгсэн.</p> | 2024.04.27-2024.05.03,<br>2024.10.01-2024.11.01 | 100% |

|     |   |   |   |                                       |  |                       |      |
|-----|---|---|---|---------------------------------------|--|-----------------------|------|
|     |   |   |   |                                       | Ээлжит цэрэг татлагууд зохион байгуулсан тухай холбогдох мэдээ тайланг маягтын дагуу боловсруулан БХЯ, ЗХЖШ-ын холбогдох газар, хэлтсүүдэд хүргүүлсэн.   |                       |      |
| 2.2 | Цэргийн гэрээт албыг иргэдэд сурталчлах, элсүүлэх ажлыг цэргийн анги, байгууллагатай хамтран зохион байгуулах | Тоо: 1<br>Чанар: Журмын хэрэгжилтийг хангах                             | Гэрээт цэргийн тоог 2-оор нэмэгдүүлсэн  | Гэрээт цэргийн тоог 2-аар нэмэгдүүлнэ | <p>Цэргийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйл, "Цэргийн албыг сайн дурын үндсэн дээр гэрээгээр хаах журам"-ын дагуу цэргийн жинхэнэ алба хаах хугацаа дуусч бэлтгэлээр халагдсан иргэдийг ажлын байраар хангах, гэрээт албанад сайн дурын үндсэн дээр элсүүлэх ажлыг зохион байгуулж байна.</p> <p>Хугацаат цэргийн алба хаасан залуучуудыг журмын дагуу цэргийн гэрээт албанад сонгон хууль хяналтын байгууллагатай хамтран гэмт хэрэгт холбогдсон эсэхийг шалгуулж, ёс суртахууны зөв төлөвшилттэй иргэдийг сонгон Зэвсэгт хүчин, Хилийн болон, Дотоодын цэргийн анги салбаруудтай хамтран ажиллаж байна.</p> <p>2024 оны байдлаар Зэвсэгт хүчиний анги салбаруудад 10 иргэн гэрээ байгуулж, цэргийн гэрээт алба хаагчаар, Хилийн цэрэгт 6 иргэн гэрээт хилчнээр, Дотоодын цэргийн анги салбарт мэргэжлийн боловсрол олгох сургалтад 2, нийт 18 иргэн ахлагчийн алба болон цэргийн гэрээт албыг сайн дурын үндсэн дээр хааж байна.</p> | 2024.05.01-2024.10.20 | 100% |
| 2.3 | Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийн сургалтыг зохион байгуулах                                 | Тоо: 1<br>Чанар: Томилгоот үүрэг гүйцэтгэх дадлага чадварыг нэмэгдүүлэх | Сургалтыг жилд 1 удаа зохион байгуулсан | Сургалтыг 1 удаа зохион байгуулах     | <p>Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам", Засгийн газрын 2023 оны 304 дүгээр тогтоолоор батлагдсан "Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай", Монгол Улсын Батлан хамгаалахын</p>  | 2024.10.21-2024.10.30 | 100% |

|     |   |   |                    |  |  |                       |      |
|-----|---|---|--------------------|--|--|-----------------------|------|
|     |   |   |                    |  | сайдын 2018 оны А/211 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт, аймгийн Засаг даргын 2024 оны А/631 дүгээр захирамж, Цэргийн штабын 2024 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 2024 оны 10 дугаар сарын 21-нээс 11 дүгээр сарын 01-ний хооронд Цэргийн штабын сургалтын танхим болон Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн сургалтын материаллаг баазыг түшиглэн цэргийн дүйцүүлэх албаны сургалтыг зохион байгуулж явууллаа.<br>2024-2026 онуудад цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах 20 алба хаагчтай цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл шатны 2 багц цаг буюу 96 цагийн, 2023-2025 онуудад цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа 10 алба хаагчтай тусгай үүргийн бэлтгэл шатны 2 багц цаг буюу 96 цагийн сургалтуудыг лекц, үзүүлэнтаниулах, биеэр үзүүлэх, харилцан ярилцах аргаар зохион байгуулж явуулсан. |                       |      |
| 2.4 | “Оюутан-цэрэг” сургалтын цэргийн өрөнхий бэлтгэл шатны сургалтыг зохион байгуулах | Тоо:1<br>Чанар: Журмын хэрэгжилтийг хангасан байх | Төлөвлөлт хийгдсэн | “Оюутан-цэрэг” цэргийн сургалтыг 1 удаа зохион байгуулна | Монгол Улсын Засаг захирагаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйл 60.1.1, 66.1 дэх хэсэг, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 32 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2024 оны А/35 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2024 оны А/208 дугаар захирамжийг тус тус үндэслэн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж тэнцсэн 22 оюутнуудыг 2024 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн долоо хоног бүрийн бямба, ням гаригуудад “Цэргийн   | 2024.04.06-2024.05.26 | 100% |

|  |   |  |                             |   |   |                       |      |
|--|---|--|-----------------------------|---|---|-----------------------|------|
|  |   |  |                             |   | ерөнхий бэлтгэл” шатны онолын сургалтыг зохион явуулж мэдээ тайланг гарган Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабт хүргүүлсэн.  |                       |      |
| Зорилт 3. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” |   |  |                             |   |   |                       |      |
| 3.1  | Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, томилгоот нэгжийн сургалтыг зохион байгуулах | Too: 1<br>Чанар: Холбогдох хууль тогтоомжийн дагуу | Сургалтыг зохион байгуулсан | Томилгоот нэгжийн бүрэлдэхүүний сургалтыг жил 1 удаа зохион байгуулна | Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүний сургалтыг жил бүр зохион байгуулж байна. Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 11.3.3, 11.4.2, 11.8, 19 дүгээр зүйлийн 19.1.8 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын 2024 оны А/110 дугаар тушаал, Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Орхон аймагт төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх гэрээний 4.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2024 оны А/341 дүгээр захирамжийг тус тус үндэслэн орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн “Хээрийн дадлага” сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 12-ноос 17-ны хооронд Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн сургалтын төвд зохион байгуулсан. Сургалтыг 3 үе шаттайгаар зохион явуулж 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр томилгоот нэгжүүдийн байлдааны буудлагатай дадлага сургалтыг зохион явуулж дүнг гарган Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын холбогдох газар, хэлтэст хүргүүлэн ажилласан. | 2024.05.10-2024.05.17 | 100% |

113

|     |   |   |
|-----|---|---|
| 3.2 | <p>Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу томилгоот нэгжүүдийг жилд 1 удаа томилгоожсон байх</p> <p>Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу томилгоот нэгжүүдийг жилд 1 удаа томилгоожсон байх</p> <p>Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу томилгоот нэгжүүдийг жилд 1 удаа томилгоожсон байх</p> | <p>Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх төлөвлөгөөтэй уялдуулан орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах эжлийн хүрээнд суман, салваа, тасалт оногдуулан данслагдсан бие бүрэлдэхүүний цэргийн шинэчилсэн тоо бүртгэл явуулах үед 2 сумын Засаг даргын Тамгын газрын дарга нартай хамтран 2024 оны 01 дугаар сарын 18, 19-нд тодотон албан тушаал мэргэжилд нь оногдуулан дансалсан.</p> <p>Тодотгоофор оногдуулан данслагдсан иргэдээс шилжилт хөдөлгөөн ороон, нас барсан, нас хэтэрсэн, эрүүл мэндийн шалтгаантай иргэдийг хасаж дайчилгааны бэлтгэл нөөцийн цэргийн хөрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтээс нөхөн томилгоожуулж, зарлан мэдээллийг багийн Засаг дарга, зохион байгуулагч нараар дамжуулан мэдэгдэх хуудас хүргүүлсэн. Мөн сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарт төлөвлөгөөний хэрэгжилтэд онцгой анхаарч, төлөвлөгөөг умрал, жил бүр тодотгох, орон нутгийн хамгаалаалтын бэлтгэлийг орон нутгийн тогтвортай хөгжлийн түвшин, нөөцийн бурдүүлэлт, хүч хэрэгслийн чадавх, томилгоот нэгжийн сургалт, бэлтгэлийн үр дүнг хангаж, шаардлагатай нөөцийг үе шаттайгаар бурдүүлж байна.</p> |
|-----|---|---|

|     |  |  |   |  |  |  |      |
|-----|--|--|---|--|--|--|------|
| 3.3 | Аймгийн цэрэг-стратегийн үнэлгээг нийгэм, эдийн засгийн статистик үзүүлэлтэд үндэслэн цэргийн ажиллагаанд үзүүлэх нөлөөг бодитойгоор тооцон боловсруулж дүгнэлт гаргах | Тоо: 1<br>Чанар: Аймгийн цэрэг-стратегийн үнэлгээг нийгэм, эдийн засгийн статистик үзүүлэлтэд үндэслэн нийцүүлэн байна | Аймгийн цэрэг-стратегийн үнэлгээг нийгэм, эдийн засгийн статистик үзүүлэлтэд үндэслэн боловсруулсан | Аймгийн цэрэг-стратегийн үнэлгээг нийгэм, эдийн засгийн статистик үзүүлэлтэд үндэслэн боловсруулна | Цэргийн штабын төлөвлөгөөний дагуу Аймгийн цэрэг-стратегийн үнэлгээг нийгэм, эдийн засгийн статистик үзүүлэлтэд үндэслэн боловсруулсан.  | 2024.12.02-2024.12.06                        | 100% |
| 3.4 | Хугацаат цэргийн алба хааж буй дайчдын цэргийн албаны үйл ажиллагатай танилцах, тэдний ар гэрт нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх.  | Тоо: 1<br>Чанар: Хугацаат цэргийн алба хааж буй дайчдын ар гэрт туслалцаа үзүүлэх                                      | Хугацаат цэргийн алба хааж буй дайчдын ар гэр 20 хүртэлх хувьд туслалцаа үзүүлсэн                   | Хугацаат цэргийн алба хааж буй дайчдын ар гэрийн 22 хүртэлх хувьд туслалцаа үзүүлэх                | Орхон аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабаас 2023 оны I, II ээлжээр хугацаат цэргийн албанд татагдсан Баян-Өндөр сумын 5 багийн 10 өрхөд 1.5 сая төгрөгийн түлээ, нүүрсний тусlamжийг ар гэрт нь дэмжлэг болгон үзүүллээ. 2024 оны I, II ээлжийн алба хаагчдад 12 дугаар сард түлээ, нүүрсний тусlamжийг ар гэрт нь дэмжлэг болгон үзүүллэнэ. | 2024.01.05-2024.01.08, 2024.12.06-2024.12.09 | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт  | Гүйцэтгэлийн түвшин |   |  |                          |                 |
|-----|----------------------------------|---|---------------------|---|--|--------------------------|-----------------|
|     |                                  |   | Суурь түвшин        | Хүрэх түвшин  | Хүрсэн түвшин (биелэлт)  | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| 1   | 2                                | 3   | 4                   | 5   | 6  | 7                        |                 |
| 1.  | БД/100 судлах                    | Tacag, салаа, рот тактикийн ажиллагаа, хориглолт, давшилт мэдлэг бататгах | 2 багц цаг          | Tacag, салаа, рот тактикийн ажиллагаа, хориглолт, давшилт мэдлэг бататгасан | Ажлын бус цагаар 7 хоногийн 2 өдрийн 80 цагийн хичээлийг бие даан судалсан.  | 2024.01.05<br>2024.05.01 | 100%            |
| 2.  | American Language Course         | book 1-6 хүртэл судлах  | 1 багц цаг          | Ангил хэлний анхан шатны мэдлэгтэй болох                                    | Ажлын бус цагаар 7 хоногийн 5 өдрийн 200 цагийн хичээлийг бие даан судалсан. | 2024.01.05<br>2024.05.01 | 100%            |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН БЭЛТГЭЛ, СУРГАЛТЫН ОФИЦЕР

ХОШУУЧ Д.НЯМЧУЛУУН

2024.12.03